

ҮЗЭМЧИН ГҮН ГОМБОЖАВЫН “ХЯТАД ОРНОО БУРХАНЫ ШАШИН ДЭЛГЭРСЭН ТҮҮХ” НОМЫН ОРЧУУЛГЫН ШҮҮМЖ

Л.Маналжав³⁴

Гомбожав нэртэй Монгол угсааны хэд хэдэн гүн хүн олны дунд алдартай билээ. Тэдний нэг нь болох Үзэмчин гүн Гомбожав 1746 онд “Хятад орноо бурхны шашин дэлгэрсэн түүх” буюу товчоор “Нангиадын номын гаргалага” (Жа-наг-чойн-жун) ч гэдэг түүхийн бүтээлээ төвд хэлээр туурвижээ. Энэхүү бүтээлийг 2005 онд Лувсанзандан хэмээх төвд багш хятад хэлээр орчуулан, төвд эхийн хамт хэвлүүлснийг³⁵ Т.Чулуун-Эрдэнэ³⁶ монгол хэлнээ орчуулан гаргав. 300 гаруй жилийн өмнө монгол эрдэмтэн төвд хэлээр бүтээсэн зохиолыг түүний төрөлх монгол хэлэнд анх удаа бүрэн эхээр нь хөрвүүлэн буулгасан нь энэ ажээ.

Дээр үед эрдэм боловсролтой хүмүүс төвд хэлээр зохиол бүтээлээ туурвиж байсан нь сөрөг зүйл бус харин тэр нь дундад зууны үед европчууд латин хэлийг шинжлэх ухааны хэл болгон хэрэглэж байсантай нэгэн адил бөгөөд Монголчуудын соёл боловсролын өндөр түвшинг илтгэнэ (Ш.Бира, 1961) гэж эрдэмтэд үздэг. Монгол оронд 1921 оныг хүртэл оюун санааны хүрээнд бурхны шашин зонхилох байрыг эзэлж, Буддын шашны боловсрол Монголын соёлын нилээд хэсгийг бүрдүүлж байв. Энэхүү өв уламжлалыг анхаарч эхэлсэн нь монгол хэл бичгийн эрдэмтдийн анхдугаар их хуралд (1959) Гандантэгчилэн хийдийн хамба Гомбожав гуайн сонгосон “Монголчуудын зохиосон зохиолын зүйл” илтгэл эхийг тавьсан бололтой. Харин академич Ш.Бирагийн орос хэлээр бичсэн “Монгольская тибетоязычная историческая литература (XVII-XIX)” бүтээл нь монгол зохиолчдын төвд хэлээр туурвисан гол гол түүхийн бүтээлүүдийн тухай өгүүлсэн судалгааны анхны зохиол байв. Энэхүү бүтээлдээ Ш.Бира “Жа-наг-чойн-жун” номын талаар тусгайлан өгүүлсэн байдаг. Уг номын төвд хэлээр бичсэн эх нь УННС-д хадгалагдаж байгаа (122 хуудастай судар хэлбэртэй) боловч хэвлэгдэж байгаагүй, төвд хэлээрхи эхийг тэр болгон ашиглаж чадахгүй учир энэхүү монгол орчуулга нь судлаачдын сонирхлыг татах нь лавтай.

Гүн Гомбожав нь зохиол бүтээлээ монгол хэлээрээ ч бас бичиж байсны жишээ бол түүний 1725 онд бичсэн “Чингис эзний алтан ургийн түүх-Гангын урсгал нэрт бичиг оршив” (түүхчид товчоор “Гангын урсгал” хэмээн нэрлэдэг) түүхийн зохиол юм.

³⁴ “Боловсрол сургалтын хүрээлэн” ТББ, УЗ-ийн тэргүүн, доктор, профессор

³⁵ 汉区佛教源流记, 贡布嘉著, 罗桑旦增译, 中国藏学出版社, 2005

³⁶ Т.Чулуун-Эрдэнэ, Боловсролын ухааны доктор (Ph.D), Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн Ази хэлний тэнхим

Гүн Гомбожавын зохиол “Жа-наг-чойн-жун” бол Монголын үндэсний түүх бичлэгийн сайн бүтээлүүдийн нэг бөгөөд сэдвийн хүрээг өргөжүүлж, түүхийн цоо шинэ материалуудыг ашигласан, монголын түүх бичлэгт иргэний сэдвийг нэмэгдүүлсэн зохиол гэж Монголын түүхчид үздэг. Энэхүү түүхэн зохиолд домог, аман түүхийн элементүүд байдаг нь зарим талаар Монголын Нууц Товчоог санагдуулдаг. Түүх бичлэгийн хувьд Хятадын уламжлалт түүх бичлэгээс огт өөр, ялгаатай нь тодорхой.

Гомбожавын “Хятад орноо бурхны шашин дэлгэрсэн түүх” зохиол нь зөвхөн шашин дэлгэрсэн түүхээр хязгаарлагдахгүй, Монгол зохиолчийн бичсэн Хятадын түүх бөгөөд түүний түүхэнд гарсан төр улсуудын мандсан, мөхсөн болон шалтгааныг нь өөрийн дүгнэлтэйгээр бичсэн нь Монголын түүх бичлэгт хувь нэмрээ оруулсан зохиол гэж түүхчид үздэг ажээ. Мөн Хятадтай хөрш зэргэлдээ оршиж байсан эртний нүүдэлчин овог аймаг болох Уйгар, Кидан нарын талаар сонирхолтой баримтуудыг дурджээ. Монголын талаар дурдахдаа: “Эртнээс Хятад, Монгол (Хүннү) зон нугууд хаяа хөдрөн амьдарсаар ирсэн. Нэгэн бошго зарлигт: Хор Монгол (Хүннү) нар Циньгийн газар нутгийг устган сүйрүүлжээ. Цинь хаан үүнийг үзээд Хор Монголчуудаас ихэд сэрэмжлэн, тэднийг алс хол хойд нутагт үлдэн хөөж, тэндээ цагаан хэрмийг барив” гэжээ. Зохиолч уг зохиолоо бичихдээ холбогдох эх зохиолыг өргөнөөр ашиглаж, нарийн ажиглалт, дүгнэлт хийдэг байсныг олон жишээнээс харж болно. Жишээлбэл: “...Тансан ламын хутагтын орноо айлчилсан зарим үйл явдлын агуулгыг би бээр (Гомбожав) түүний “Цадигийн хураангуйлсан” хоёр хэсэг, “цадигийн” дэлгэрүүлснээс арван хэсэг тус бүрээс хураангуйлан авч, энэхүү дэвтэртээ оруулсан болно. Жич бас Тансан ламын зохиосон “Хутагтын орны илт онол арван бүлэг” хийгээд мөн “Их Тан улсын баруун этгээдэд зорчсон тэмдэглэл”-ийн арван хэсгийг нягтлан судлах үед, тэрбээр үнэхээр Хутагтын орноо жуулчлан, түүнийг бодитой үзсэн мэт байдаг гэжээ.

Энэхүү бүтээлдээ зохиогч Буддын шашин дэлгэрсэн тухай өгүүлэх зорилгыг тавьсан боловч “Шашныг баригч их багш нар аль цагт гарсан товч хураангуй” хоёрдугаар бүлэгт Дао, Күнз, Буддын сургаалын талаар өгүүлжээ. Мөн бусад шашны талаар дурдахдаа Тан улсын үед Тохаро буюу цагаан малгайтнууд Нангиад оронд нэвтэрсэн тухай өгүүлжээ. Мөн Чингис хааны байлдан дагуулалтын үед Тэнгэрийн эзэн хэмээн тахин шүтэхтэй тохиосон тухай өгүүлээд уг шашныг үндэслэгч нь гэгээн Мариягаас төрсөн Есүс гэх мэтээр өгүүлжээ. Энэ бүгдийг өгүүлсний дараа Ялж Төгс Нөгчсөн Бурхны шашин дэлгэрсэн тухай Буддын самадич нарын тэмдэглэлийг гол болгон өгүүлсэн байна. Энэ бүхэн номын зохиогч өргөн сонирхол, мэдлэгтэй хүн байсныг өгүүлнэ.

Энэхүү орчуулга нь Буддын судлалын нэр томъёог орчуулах, ерөөс орчуулга зүйд чухал хувь нэмэр оруулсан ажил болсныг онцлон тэмдэглэж байна. Аливаа ном зохиолыг орчуулахад эх зохиолын утга агуулгыг бүрэн гүйцэд хөрвүүлэн буулгахаас гадна эх бичгийн найруулга, бичлэгийн хэлбэр маягтай адил төстэй байхыг шаарддаг зарчим бий. Энэхүү номын орчуулга энэ зарчимд бүрэн нийцсэн орчуулга болжээ гэж

хятад хэлнээс монгол хэлэнд хөрвүүлсэн орчуулгыг хянан тохиолдуулсны хувьд үзэж байна.

Энэхүү номыг хятад хэлнээс орчуулахад номыг анх туурвисан төвд хэлээрхи эхтэй тулгаж үзэн орчуулсан зүйл олон байсан нь лавтай. Энд түүхийн ухааны шинжлэх ухааны доктор Л.Тэрбиш “Төвд эхээс нь харж, бага сага тусалсан зүйл буйгаа” номын уялга үгэнд даруухнаар дурдсан боловч Л.Тэрбишийн төвд бичгийн болон бурхны шашны түүх, соёлын талаархи гүн гүнзгий мэдлэг тус дэм болсон нь зүй ёсны хэрэг. Эрдэм номт эцгийн үйлсийг үргэлжлүүлэн, энэхүү том ажлын ард гарсан залуу судлаач Т.Чулуун-Эрдэнэ маань цаашид ч олон ном орчуулж, судлаачийн ажил хийнэ гэдэгт эргэлзэхгүй байна.

Энэхүү номыг орчуулахдаа гурван мянгаад тайлбар, зүүлтийг хийсэн нь судлаачид ашиглахад тун дөхөмтэй болжээ.

Бас нэг анхаарал татаж байгаа зүйл нь орчуулгын хэл найруулга, ялангуяа Буддын шашны нэр томъёог төвд, монгол, хятад хэлээр яг оноож, дүйлгэснийг орчуулгаас олж үзэж болно. Доорх жишээг үзнэ үү:

Билиг барамидын таван зуут-般若五百颂
Билиг барамидын хураангуй-般若摄义
Билиг барамидын жижиг бүлэг-小品般若
Билиг барамидын байгууламж даяар-无边压严般若经
Насны судар-长寿经
Дара эхийн 108 алдар-度母一百零八名号
Хоосноо урвуулахуй-千变
Сайн өнгөт-善色
Гэм эрүү арилгахуй-除罪
Дээд сайн оюун-最佳智慧
Ведийн хаан бусдаар үл чадагч-明王他人所不能胜者
Майдарын тогтоол-弥勒陀罗尼
Гурван орны ялгуусан онол-三界胜品
Цогт-吉祥
Хамаг бурхны алдар-诸佛名号
Зан үйл-仪轨
Их амгалан-大乐
Бүтээлийн арга-修习法
Хутагт очир залуугийн дандар-圣金刚童子怛特罗
Таван үсгийн тусгай өгүүлэл-五字专论
Билгийн чанад хүрсний бүтээлийн арга-般若波罗密多修行法
Тамын судар-地狱经

Сумахари хэмээгч судар-苏摩哈利

Арван буяны цааз-十善律

Увш-居士

Хамаг үндсийг буйд өгүүлэгч винайн утгын хураангуй-根本说一切 有部毗奈
耶略撮

Мөрийг номлох-道论

Очироор огтлогчийн дига-金刚经注释

Их хөлгөний абидарма-大乘论藏

Арван найман хоосон чанар-十八空性

Төв үзлийн зуут үсгийн язгуурын тайлбар 中论百字本注

Тансан ламын цадиг-玄奘法师传

Гүн Гомбожав нэр томъёог нааш цааш хөрвүүлэн орчуулсан тухайгаа ийнхүү өгүүлжээ: “...орон хийгээд бодгал тэргүүтний нэрийн тайлбар хийгээд орчуулах боломжтой, орчуулах хэрэгтэй нүгүүдийг алин зохистой дууны утгаар орчуулав... Номын нэрийн зонхийг нь төвдөөр талбив... Мэдэхгүй хийгээд тулгамдсан, самгардсан хийгээд шалгах чөлөө болоогүй хэсгүүдийг нэр, утгыг хэрхэн орчуулбал амар болохыг харгалзан орчуулав. Амар хялбар нугуудыг дээр тодруулсанчлан тус тусад нь үйлдэв” хэмээжээ.

Төвд хэлээр анх бичсэн энэхүү түүхийн зохиолыг монгол хэлээр орчуулсан нь юуны өмнө манай дорно дахины судлаачид, бурхны шашин судлаачид болон түүхчдийн судалгаа шинжилгээний ажилд чухал хэрэглэгдэхүүн болох эх сурвалжийг нээн өглөө гэж үзнэ. Монголын түүх, соёлын өв олон хэлээр тэмдэглэгдэн бичигдсэн нь нэг талаас бидний бахархал, нөгөө талаас заавал орчуулах шаардлага гардаг бэрхшээл. Төвд болон бусад хэлээр бичсэн бүтээлүүдийг гадаад, дотоодын эх бичиг судлаачид, хэл шинжлэлч-орчуулагч нар шинээр нээн олж, орчуулан судлаж байгаа нь Монголын түүх, соёл арвин баялаг өвтэйг гэрчилж байна. Тэдгээрийн нэг болсон монгол хүн айл хөрш орныхоо түүхийг бичсэн нэгэн бүтээл судлаачид, уншигчдад хүрч байна.